



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Замын-Үүд сумын Борхойн баян бүрд ОНӨААТҮГазрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ДГА-2022/07/НА-СТА-ААТҮГ

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2022 он	Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Багийн ахлагч аудитор: Ш.Сувдаа Цахим хаяг: smaudit97@gmail.com
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34

Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.09.15 № 16/315

танай _____-ны № _____-т

БОРХОЙН БАЯН БҮРД ОНӨААТҮГ-ЫН
ДАРГА З.ЦЭЦЭНТӨГС ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Борхойн баян бүрд ОНӨ ААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Нэг. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

		/сая төгрөгөөр/	
	Үзүүлэлт	2020.12.31	2021.12.31
Санхүүгийн байдлын тайлан			
	Эргэлтийн хөрөнгийн дүн	7.0	24.6
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	1,381.4
	Нийт хөрөнгийн дүн	7.0	1,406.0
	Нийт өр төлбөрийн дүн	1.1	1.2
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	5.9	1,404.8
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	7.0	1,406.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан			
	Үйл ажиллагааны орлогын дүн	15.4	183.3
	Үйл ажиллагааны зардлын дүн	8.8	245.2
	Үйл ажиллагааны үр дүн	6.5	9.5
	Үйл ажиллагааны бус үр дүн		
	Үйл ажиллагааны нийт үр дүн	5.8	9.4
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан			
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.2	1,389.4
	Тайлант оны үр дүн	5.8	15.4
	Эцсийн үлдэгдэл	6.0	1,404.8
Мөнгөн гүйлгээний тайлан			
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	15.4	254.9
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	10.0	240.4
	Үйл ажиллагааны ЦМГ	5.4	14.5
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	-	14.5
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	-	13.2
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	5.4	13.2
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	5.4
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5.4	18.7

Хоёр. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Борхойн баян бүрд ОНӨААТҮГ нь Дорноговь аймгийн Замын Үүд сумын Иргэдийн төлөөлөгчийн хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 07/12 дугаар тогтоолыг үндэслэн аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 30-ний өдрийн А/10 дугаар захирамжаар байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд “Аймгийн нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ...5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;...” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Замын Үүд сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар томилж байгаа нь Төрийн өмч, орон нутгийн өмчийн тухай хууль / эрх зүйн акт/ заалттай нийцэж байна.

Гурав. Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Борхойн баян бүрд ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 61,0 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам”-ын 3.7-д “...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна” гэсэн заалтай нийцэж байна.

Дөрөв. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Борхойн баян бүрд ОНӨААТҮГ нь тайлант онд нийт 245,1 мянган төгрөгийн 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 47 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилтэй байна.

Тав. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шилэн дансны мэдээлэл бүрэн оруулах, Санхүү, татвар, Нийгмийн даатгалын тайлангуудыг зөрүүтэй гаргадаг асуудлыг таслан зогсоох

Зургаа. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 96.9 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 96.2 сая төгрөгийн 5 алдааг залруулж, 1 албан шаардлага хүргүүлж, 0.7 сая төгрөгийн алдаа зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа:

- Борлуулалтын орлогыг санхүүгийн тайлан 183,356,761.45 төгрөгөөр ААНОАТ-ын тайланд 254,912,260 төгрөгөөр тайлагнасан нь Монгол улсын НББТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг алдагдуулжээ.
- Борлуулалт хийгээгүй боловч зардлыг ББӨ-гаар зардлын ангилал зөрүүлэн бүртгэсэн нь Монгол улсын НББТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг алдагдуулжээ.
- Цалингийн зэсээр олговол зохих цалин 53,284,000 Төгрөг байхад ХХОАТ-ын тайлан 44,277,977.72 төгрөгөөр тусгаж тайлагнасан нь Монгол улсын НББТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг алдагдуулжээ.
- Цалингаас суутгасан ХХОАТ 3,673,309.4 төгрөг байхад татварын тайланд 3,139,314.51 төгрөгөөр тайлагнасан нь Монгол улсын НББТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг алдагдуулжээ.
- ААНОАТ-г санхүүгийн тайланд 98813.62 төгрөг төлөхөөр тайлагнасан боловч ААНОАТ-ын тайланд тусгаагүй нь Монгол улсын НББТухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан “үнэн зөв байх” гэсэн зарчмыг алдагдуулжээ.

Зөвлөмж:

Олгосон цалин бүрээс НДШ суутгаж байх

Албан шаардлага:

Өмнөх зөвлөмжийг хэрэгжүүлээгүй давтан гаргасан шилэн дансанд 149 мэдээлэл оруулахаас 47 мэдээлэл хугацаа хоцруулж мэдээлсэн.

7.1 Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
A	1	2	3	4	5	7	8	9	10
1	ОНӨ	1	1			1			
	НИЙТ								

7.2 Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл:

/сая төгрөгөөр/

№	Төсвийн захирагчийн ангилал	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
A	1	2	3	4	5	6	7	8	9	10	11
1	ОНӨ	7	96.9					1	-	1	0.7
	НИЙТ	7	96.9	5	96.2	-	-	1	-	1	0.7